



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/160

Мандалговь

Өлзийт сумын уугуул ахмад настан
Дашдаваа овогтой Отгонбаатарт
тусламж үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6/г/, Сангийн сайдын 2018 оны 318 тоот тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 7 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Өлзийт сумын уугуул иргэн Дашдаваа овогтой Отгонбаатар нь хүнд өвчний улмаас Улаанбаатар хотод 3-р шатлалын эмнэлэгт оношилгоо, эмчилгээ хийлгэхэд тулгараад байгаа санхүүгийн хүндрэлтэй байдал, аймгийн Засаг даргад хандаж ирүүлсэн өргөдлийг харгалзан үзэж нэг удаагийн буцалтгүй тусламжийг үзүүлсүгэй.

Хоёр. Тусламжид шаардагдах 300 000 (Гурван зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190439